*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# АХМАД, СЭТГЭЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ГАНЦЭЦЭГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчний эрт илрүүлгийг нэмэгдүүлж, авчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэргийлж болох эндэгдлийг иргэд, хамт олны оролцоотой бууруулж, нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг эрчимжүүлэх** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.2.** Өсвөр үеийхэнд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олох сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | Сургалтад хамрагдсан хүүхдийн тоо | | 500 | Даланзадгад сумын 3, 5, 6-р сургуулийн нийт 679 хүүхдэд цахим халдлага, хүчирхийлэл ялгаварлан гадуурхах дээрэлхэх, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээ, хорт зан үйлээс ангид байх нь сэдвээр сургалт зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгсөн. Мөн СЭМҮТ-ийн өсвөр үеийн клиникийн эрхлэгч, хүүхдийн сэтгэцийн эмч А.Цэрэндолгор хүүхэд, өсвөр үеийнхэн амиа хорлох үйлдлээс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийн нөлөөллөөс үүдэлтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон гэр бүлийн асран хамгаалагчдад 50 хүнд тандалт судалгаа, сургалт арга хэмжээг зохион байгуулсан. Итгэлтэй амьдрал төвийн Т.Хатанхүү эмчээр Сэврэй, Ханхонгор, | 3-6 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гурвантэс сумын ЕБС-ийн 6-12 ангийн суралцагчдад "Стрессээ зохицуулж, өөрийгөө удирдахуй", "Сэтгэл хөдлөлөө хянах нь", хамт олны уур амьсгалыг дээшлүүлэх, эерэг мэдрэмжийг түгээх бүлгийн зөвлөгөөг нийт 100 гаруй хүүхдэд хүргэж, судалгааг авсан байна.<br>Өсвөр үеийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих сонсоё, ойлгоё, хайрлая зөвлөгөө хүргэсэн. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.3.** Иргэд, албан байгууллага, хамт олонд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулах | Хамрагдсан иргэдийн тоо | | 50-100 | Төрийн 5 албан байгууллага, /Улсын бүртгэл, 5-р сургууль, Хаан хүнс ХХК, хувийн 1 байгууллагад "Стрессийн тухай ойлголт, уур бухимдалаа зохицуулах нь, стрессийг даван туулах арга зам сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж нийт 136 хүнд хүргэсэн.<br>ЭМГ-ын Facebook цахим хаягт Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр нийт 6 мэдээлэл 16 төрлөөр бэлтгэж, олон нийтийг мэдээллээр хангасан.<br>"Эрчүүдийн сэтгэцийн эрүүл мэнд", "Дэлгэцийн донголтоос сэргийлэе"<br>" зөвлөмж байрлуулсан.<br>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн баг 3 дугаар сарын 31-ээс 04 дүгээр сарын 04-ыг хүртэл эмч нарын үзлэг, оношилгоо, зөвлөгөөг өгөх "Mini-International Neuropsychiatric Interview (M.I.N.I.)буюу мэдрэл сэтгэцийн эмгэгийг оношлох ярилцлага асуумжийн хүчин төгөлдөржүүлэлтийг хийх, судалгааны аргачлалыг баталгаажуулах зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтыг судлахаар нийт 89 хүнд давхардсан тоогоор үзлэгт хамруулан, өмнө нь ямар нэгэн сэтгэл зүйн тусламж авч байгаагүй, эмч нарын хяналтад байхгүй 22 хүнийг шинээр хамруулсан нь онцлог байлаа. | 3-6 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөн сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг Даланзадгад сумын 10 багийн 50 гаруй иргэдэд зохион байгууллаа.<br>Эрүүл мэндийн газрын дарга Ц.Жавзандуламтай уулзалт хийж 4 хоногийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн арга хэмжээгээ танилцуулан, цаашид хамтарч ажиллахаа илэрхийлсэн ба Итгэлтэй амьдрал төвийн үйл ажиллагаатай танилцан арга зүйгээр хангаж ажилласан. | | |
| 3. | **Арга хэмжээ 1.4.** ЭМГ-ын удирдах албан тушаалтан, мэргэжилтэн, алба хаагчдад байгууллагын дотоодын сургалтаар сэтгэцийн эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулах | Хамрагдсан ажилчдын тоо | | 20-34 | Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМА, сэтгэл зүйч Б.Нандинцэцэгтэй хамтран Эрүүл мэндийн газрын эмч мэргэжилтнүүддээ “Би буюу өөрийн сэтгэл зүйн онцлогыг мэдэх”, “Ажлын байран дах стрессийг даван туулах арга зам” сэдвээр сургалт зохион байгуулж ажилласан. | 4-5 сар | 100% |
| 4. | **Арга хэмжээ 1.5.** “Итгэлтэй амьдрал төв”-д ЭМГ-ын бодлогын мэргэжилтэнүүдтэй хамтарч хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааг жигдрүүлэх зөвлөн туслах баг гарч ажиллах | Өгсөн зөвлөмж, уулзалтын тоо | 1 удаа | 1 удаа | Итгэлтэй амьдрал төвд ЭМГ-ын УТСХ, ЭТҮХ-ийн дарга нараар ахлуулсан баг 7 хүний бүрэлдэхүүнтэй дэмжлэгт хяналтын баг ажилласан. Тус дэмжлэгт хяналтын хүрээнд дүгнэлт зөвлөмжийг 2025 оны 6 дугаар сарын 12-нд хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг 6 дугаар сарын 26-нд ирүүлэх албан тоот хүргүүлсэн. | 2-12 сар | 100% |
| 5. | **Арга хэмжээ 1.6.** Хавдрын бай, хими, хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдаж буй иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх | Сэтгэл зүйн зөвлөгөө авсан үйлчлүүлэгчийн тоо | 5 | 3 | Бусийн оношилгоо эмчилгээний төвийн хавдар, хөнгөвчлөх эмчилгээний тасгийн үйлчлүүлэгч иргэдэд сэтгэл гутрал, сэтгэл түгшилт сэдвээр 2 удаагийн зөвлөгөө өгч ажилласан. 1 хүн өөрөө зөвлөгөө авахаас татгалзсан. | 2-12 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6. | **Арга хэмжээ 1.7.** Даланзадгад сумын 10 багийн ахмадуудад эрүүл амьдрах, чанартай урт наслах эрүүл мэндийг дэмжих чиглэлээр “Эрүүл насжилт” сургалт, үнэлгээ, нөлөөлийн арга хэмжээг зохион байгуулах | Сургалтад хамрагдсан ахмадын тоо | - | 300 | Даланзадгад сумын нийт хүн амын 7,9% нь 60-аас дээш насны ахмад ээзлж байна. 10 багийн 300 ахмад настанд “Эрүүл насжилт, идэвхтэй хөдөлгөөн, зохистой хооллолт” сэдвээр сургалтыг зохион байгуулж, хөдөлгөөний чадвар бууралтын үнэлгээг сургалтад оролцогчдын 81% буюу 242 ахмадаас авсан байна. | 1-2 сард | 100% |
| 7. | **Арга хэмжээ 1.8.** Ахмадын хөдөлгөөн бууруулалтын оношлогоог хийж, нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлийг үнэлэх судалгааг хийх | | | 242 | ICOPE үнэлгээний дагуу хөдөлгөөний чадавхи бууралтыг илрүүлэх сорилын үнэлгээг хийсэн. Тус үнэлгээгээр 23,9% нь хөдөлгөөний чадвар буурaлттай, 69,3% нь артерийн даралт өндөр, 61,5% нь өдөр тутамдаа тогтмол 3-4 эм ууж хэрэглэдэг болох нь тогтоогдсон. Биеийн найрлага хэмжигч аппаратаар үнэлэхэд нийт ахмадын 50% хэвлийн өөхлөлттэй, 70% нь ус шингэний дутагдалтай, насжилт дунджаар 5-11 насны зөрүүтэй, шим тэжээлийн дутагдалтай 13 ахмад настан байсан. | 2-3 сард | 100% |
| 8. | **Арга хэмжээ 1.9.** Говь дент шүдний эмнэлэгтэй хамтран ахмадын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шүдний үзлэгээр илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах | Шүдний үзлэгт хамрагдсан ахмадын тоо, эрүүлжүүлсэн тоо | - | 63-70 | Говь дент шүдний эмнэлэг, Ахмадын чөлөөт холбоо, Ахмадын хороотой хамтран Даланзадгад сумын 10 багийн 80 гаруй ахмадад шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгууллаа. Үзлэгээр 63 ахмад настан шүд ломбодуулах, буйлний үрэвсэлийн эмчилгээ, шүд авахуулах, хиймэл шүд хийлгэх шаардлагатай байлаа. Үүний үр дүнд ломбо, буйлны үрэвсэл, сувгийн эмчилгээ хийж 63 ахмадын шүдийг эрүүлжүүлсэн байна. ЭМГ-ын ахмад настан 11 хүн үзлэгт хамрагдаж, эмчилгээ үйлчилгээг авсан. | 2-3 сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | **Арга хэмжээ 1.10.** Геронтологийн үндэсний төвтэй хамтарч ЭМС-ын А/22 тушаал “Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар”-ыг анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлэх удирдлага арга зүйгээр хангах чиглэлээр сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах | Сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний тоо | | | Геронтологийн үндэсний төв рүү хамтарч ажиллах албан тоотыг 1 сард хүргүүлсэн. Мөн АЗДТГ, Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр “Ахмад настны цогц тусламж үйлчилгээ” эмч мэргэжилтэн, хөдөлмөр халамж үйлчилгээний ажилтанг чадавхуулах сургалтын удирдамжийг боловсруулан ажиллаж байна. | 3-5 сард | 50% |
| 10. | **Арга хэмжээ 1.12**. Геронтологийн үндэсний төвтэй хамтарч ахмадын урьдчилан сэргийлэх үзлэгийг аймгийн хэмжээнд зохион байгуулах | Үзлэгт хамрагдсан ахмадын тоо | | 500-600 | Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 2 дугаар сарыг “Ахмад настны эрүүл мэндийг дэмжих сар“ болгон зарласантай холбоотой Даланзадгад сумын ЗДТГ, ЭМГ, БОЭТ-тэй хамтран ахмад настны эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, эрүүл урт наслах амьдралын чанарыг сайжруулах зорилгоор 10 багийн төв дээр үзлэг оношилгоог зохион байгуулсан. Үзлэгт нийт 798 ахмад настан хамрагдан 7 чиглэлийн эмчийн үзлэгт /ЭХО-814, ЭКГ-629, зүрх судас-516, ахмад настан-102, нүд-749, чих хамар хоолой-585, арьс харшил-534, сүрьеэ-701/ давхардсан тоогоор 4630 үзлэг хийгдэн шинэ болон хуучин өвчлөлүүдийг илрүүлэн холбогдох арга хэмжээг тухай бүрт нь авч ажилласан. Үзлэгээр үр дүнгийн хувьд шинээр элэгний хавдрын тохиолдол 4, сүрьеэгийн сэжигтэй тохиолдол 2, хурц мухар олгойн үрэвсэл-1, нүдний хурц даралт ихсэлт 4-ийг илрүүлж эмчилгээ оношилгоог хийсэн ба лавлагаа 3-р шатлалд 5, орон нутагтаа БОЭТ-д онош тодруулахаар багажийн | 2-6 сард | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон бусад шинжилгээнд 126 хүнийг илгээсэн байна. | | |
| 11. | **Арга хэмжээ 1.15.** Байнгийн асаргаа сувилгаатай ахмадын гэрийн эргэлтийг сайжруулах ажлыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллах | Удирдлага арга зүйгээр хангасан тоо, зөвлөмж | - | 1 удаа | Өрх, сумын эрүүл мэндийн төвөөс байнгийн асарга сувилгаатай ахмадын нэрсийг авч, ХХҮГ-ын халамжийн сангаас тэтгэмж авдаг ахмадыг нэрстэй тулгалт хийх ажлыг эхлүүлж байна. Үүний хүрээнд 10 сард БОЭТ, өрхийн ЭМТ-тэй хамтран Далангадгадын 34-40 ахмадад хүрч үйлчилнэ. Мөн сумдын ЭМТ рүү чиглэл хүргүүлж ажиллана. | 1-11 сард | 50% |
| 12. | **Арга хэмжээ 1.17.** ЭМГ-ын ахмадын сан, байгууллагын ахмадын зөвлөл ажиллах тухай тушаал гаргах, журам боловсруулан батлуулж, байгууллагын ахмадад чиглэсэн арга хэмжээг өргөжүүлэх | Батлагдсан тушаал, төлөвлөгөө тайлан | - | 2 тушаал | ЭМГ-ын ахмадын сан болон зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журамын төслийг боловсруулан удирдагын багаас санал авч тушаалыг батлуулсан. Мөн аймгийн төрийн сангаас ахмадын сангийн дансыг нээлгүүлсэн. 3-р улиралд байгууллагын ахмадын зөвлөлдөө танилцуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боломруулна. | 2-11 сард | 90% |
| 13. | **Арга хэмжээ 1.18.** Олон нийтийн эрүүл мэндийн ажилтны ажиллах нөхцөл, урамшуулал, зохион байгууллалтыг тусгасан журам, бодлогын баримт бичиг боловсруулах | Батлагдсан журам, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан | | 1 тушаал | Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарт олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудыг ажиллуулах, урамшуулах, удирдлага зохион байгуулалтын асуудлыг тусгасан журмын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулах тушаалыг гаргаж, /ЭМГ-ын даргын 2025 оны 01 дүгээр сарын 27 өдөр А/06 тушаал/ ажлын хэсэг 3 удаагийн уулзалтыг хийсэн. Тус уулзалтын үеэр олон нийтийн эрүүл мэндийн ажилтанд шаардлагатай хэрэгслийн жагсаалтын төсөл, /Энгэрийн тэмдэг, үүргэвч, хантааж, бусад хэрэглэгдэхүүн....../ гаргасан. Мөн ОНЭМА-ны ажиллах журмын төсөл, 2025 онд зохион | 2-11 сард | 80% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний төсөл зэргийг боловсруулсан. Тухайн гаргасан бүх төслүүдийг НҮБ-ын хүүхдийн сангийн мэргэжилтэн х.Уранчимэгт эхний байдлаар танилцуулан ажиллаж байна. Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн санхүүжилтээр ОНЭМА-ыг давтан бэлгэх ажлыг 3,4-р улиралд зохион байгуулахаар төлөвлөж байна. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Эмч нарын баярт зориулсан подкаст | Гүйцэтгэсэн ажлын гэрээ, подкастын тоо | - | 3 | Эмч нарын баярт зориулсан “ЭМЧЭЭ СОНСОЁ” ахмад, дунд, залуу эмч нарын төлөөлөл 6 эмч, мэргэжилтэн оролцсон "Даланзадгай яриа" подкаст нэвтрүүлгийг мэлмий.мн цахим хуудастай хамтран зохион байгуулж ажилласан. Тус арга хэмжээнд салбарын ямар эмч нарыг оролцуулах тухай санлыг удирдлагын багаас санал авч сонгож ахмад үеийн төлөөлөл хүний гавъяат эмч Ш.Пүрвээ, хүүхдийн эмч Хүүхэндүү нар, дунд үеийн төлөөллөөс гэмтлийн эмч Гансүх, эмэгтэйчүүдийн эмч Б.Сэлэнгэ нар, залуу эмч нарын төлөөлөл зүрх судасны эмч Бямбадорж, Ноён сумын ЭМТ-ийн ерөнхий эмч Энхжин нар оролцож анх эмч мэргэжлээр төгсөж ирээд ажлын гараагаа хэрхэн яаж эхэлсэн түүхэн | 3 сард | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | замнал, ололт амжилт, туршлага, шинэ технологийг орон нутагтаа нутагшуулахаар зорьж байгаа гээд олон сайхан зүйлийг энгийнээр ярьж олон нийтэд хүргэсэн. Подкастыг 18500 хүн үзэж, 290 хүн хандалт хийж, 55 хүн коммент бичиж, 75 share хийсэн байна. | | |
| 2. | Сувилагч нарын баярт зориулсан контент | Гүйцэтгэсэн ажлын гэрээ, контентын тоо | - | 6 | Бусийн оношилгоо эмчилгээний төвийн Сувилахуйн албатай хамтарч Төрөх эмэгтэйчүүдийн тасгийн эх баригч Б.Цэрэнбадам, уламжлалт, нөхөн сэргээх эмчилгээний тасгийн сувилагч А.Баатаржав, дотрын тасгийн дотор хөнгөвчлөх эмчилгээний сувилагч Х.Уянга нар, гурван ӨЭМТ-ийн дарга, ахлах сувилагч нартай ярилцаж цувралт контентод оролцох хүмүүсийг сонгож, ажил үүрэг, үйлчилгээг давхцалгүйгээр олон нийтэд хүргэх зорилгоор Энхийн хүслэн өрхийн ЭМТ-ийн эх баригч Э.Сумъяа, Шимбилэг ӨЭМТ-ийн Дархлаажуулалт хариуцсан вакцинатор сувилагч С.Шүрхүү, Өнө-Орших ӨЭМТ-ийн ахлах сувилагч С.Эрдэнэчимэг нартай хамтарч "Сувилагчийн нэг өдөр" цуврал 6 удаагийн контентийг Судваа студийн сэтгүүлч, зураглаачийг арга зүйгээр хангаж бичлэгийн зураг авалт, дүрсийг өөрийн биеэр явж хийлсэн. Тус 6 контентууд маань өөр өөрийн онцлог шинжийг гаргахыг илүүд үзэж ярилцаж бүтээснээр онцлог болсон гэж бодож байна. | 5 сард | 100% |
| 3. | Эрүүл мэндийн газар, ЭМСалбарын номонд орох мэдээлэл нэгтгэх | Цуглуулсан материал | - | 1 | ЭМГ-ын даргаас үүрэг даалгавар авч ахмадын зөвлөлийн дарга Б.Мидэрсүрэн | 6 сард | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | эмчтэй хамтран Эрүүл мэндийн газар, ЭМС-ын хөгжил, үе үеийн удирдлагууд, хүний нөөц, эрүүл мэндийн үйл ажиллагааны талаарх товч статистик, санхүүжилт, эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлсэн орон нутгийн дэд хөтөлбөрүүд, үр дүн, эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл ба шинээр нутагшуулсан шинэ технологиуд, томоохон хийгдсэн үр дүнтэй үйл ажиллагаанууд гээд холбогдох материалуудыг УТСХ, НЭМТ, ЭТҮХ, ХШҮМХ-үүдийн дарга, холбогдох мэргэжилтнүүдээс авч нэгтгэн номын эмхэтгэлд оруулан хугацаанд нь даргад хүргэж ажилласан. | | |
| 4. | "НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭС" чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад хамтрах | | | | Аймгийн засаг даргын тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар хамтран 2025 оны 4 дүгээр сарын 28-аас, 5 дугаар сарын 02-ыг хүртэл 5 хоногийн сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтыг Монголын Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн захирал Б.Машбадрах, гишүүн Д.Байгалмаа нар удирдан чиглүүлж явууллаа.<br>Сургалтад Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүд, Зооноз өвчин судлалын төвийн дарга, мэргэжилтэн, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМАжилтан, Говь дент, Итгэлтэй амьдрал төвийн эмч, арга зүйч нар, 23-р цэцэрлэгийн эмч гээд нийт 27 хүнийг хамруулан 5 багц цаг, гэрчилгээг олгов. | 5 сард | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| 5. | Дархлаажуулалтын аянд хамтарч ажиллах | | | | Дархлаажуулалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, олон нийтэд вакцины ач холбогдол, аюулгүй байдлын талаарх мэдлэг олгох, вакцинаар сэргийлэгддэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дархлаажуулалтын өдөрлөгийг зохион байгуулсан. Даланзадгад сумын хэмжээнд Ерөнхий боловсролын долоон сургууль бүр дээр өдөрлөг зохион байгуулж ажилласан. Өдөрлөгийн нээлтийг Улсын тэргүүний 1-р сургууль дээр зохион байгуулсан. Өдөрлөгийн нээлтэд 450 гаруй хүүхэд ирж мэдээлэл авсан. Өдөрлөгийн хүрээнд өртөөчилсөн сургалт мэдээллийн арга хэмжээ, 5 болон 6 дугаар ангиудад анги тус бүрээр сургалт хийх, сурагчид, эцэг эх, багш ажилчдад сургалт, мэдээлэл хийж зорилтот бүлгийн нийт 958 хүнтэй уулзалт зохион байгуулж ажилласан. Арга хэмжээний хүрээнд нийт 2150 хүүхэд, 1652 эцэг, эх, асран хамгаалагч, 23 боловсролын байгууллагын ажилчид албан хаагчид оролцсон байна. 2. Даланзадгад сумын ЕБС-ын 7 сургуулийн нийт 9185 хүүхдүүдийн вакцинжуулалтыг сургууль тус бүрээр шүүж дутуу тунтай хүүхдүүдийг дархлаажуулах, мэдээллийг цахимд оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. | 5 сар | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 2. Өөрийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг болон удирлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу шаардлагатай цахим болон тамхимын сургалтад харагдана | | 5 | 8 | 1.Томуу, томуу төст өвчний өнөөгийн байдал, хариу арга хэмжээ<br>2.Улаан бурханы эмнэлзүйн оношлогоо, эмчилгээ<br>3.ЭМЯ-ны салбарын хяналтын багийн дүнгийн хурал<br>4.Хачигаар дамжих зарим халдваруудын байгалын голомтын төлөв байдал, тархвар судлал<br>5.Хүүхдийн зуслангийн хөгжлийн бодлого, тогтолцооны шинэчлэл<br>6.Нийгмийн эрүүл мэндийн үндэс чадавхжуулах сургалт<br>7.Улаан бурханы нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ<br>8.Халдварт бус өвчний өнөөгийн байдал, анхаарах асуудал<br>9.Авилгын эсрэг нэгдэе сэдвээр 1 танхим, 8 цахим сургалтад хамрагдсан байна. | 1-6 сард | 100% |
| 2. | Удирдлагын акедемийн төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад хамрагдах | | | | Цаг хугацааны хувьд болон санхүүгээс шалтгаалан суралцаагүй байна. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Ахлах, Сэтгэл хариуцсан мэргэжилтэн
( Албан тушаал )

/ Б. Ганцэцэг /
( Нэр, гарын үсэг )

2025 – 6 – 19
( Огноо )